

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | |
|---|----|
| 1. Аудитын гэрчилгээ | 2 |
| 2. Аудитын тайлан | 4 |
| 2.1. Оршил | 4 |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 4 |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 5 |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 5 |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 5 |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд | 6 |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 6 |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 7 |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 7 |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл | 7 |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт | 7 |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 7 |
| 3. Менежментийн захидал | 8 |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан | 9 |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 9 |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 10 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 12 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 14 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 15 |
| 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан | 17 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 18 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХАН ХЭНТИЙН УЛСЫН ТУСГАЙ
ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Ц.ДУЛАМСҮРЭН ТАНАА

2020.02.20 № 06/537
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус байгууллагын дарга Ц.Дуламсүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн зардлын данстай холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 19-нээс 2020 оны 02 дугаар сарын 12-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Дөлгөөнхайрхан уул Аудит” ХХК-ийн аудитор Н.Янжмаа, аудиторов туслах А.Золзаяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хан хэнтийн дархан цаазат газар, Өндөрхаан уулын байгалийн цогцолборт газар, Хангал нуурын байгалийн дурсгалт газар, Биндэръяа уулын байгалын дурсгалт газрын хилийн зааг дотор багтаж буй газар нутгийн биологийн төрөл зүйл, томоохон гол мөрөн, байгаль түүх, соёлын дурсгалын байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, шинжлэн судалж зүй зохистой ашиглах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрөөс экологийн талаар баримтлах төрийн бодлого, тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acoluos” программ хангамж ашиглаж байна.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 24 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож материаллаг байдлын түвшинг 17,742.9 мянган төгрөгөөр тооцсон.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 126,573.1 мянган төгрөгөөр буюу 14.4 хувиар өссөн байна. Энэ нь бараа материал, үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /мянган төгрөг/ Өөрчлөлт |
|---|------------------|--------------------|-----------------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 192.4 | - | -192.4 |
| Бараа материал | 134,997.2 | 173,893.6 | 38,896.4 |
| Үндсэн хөрөнгө | 746,236.9 | 834,106.0 | 87,869.1 |
| Нийт хөрөнгө | 881,426.5 | 1,007,999.6 | 126,573.1 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 881,426.5 | 1,007,999.6 | 126,573.1 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 881,426.5 | 1,007,999.6 | 126,573.1 |

Авлага дансны үлдэгдэл буурсан нь 2018 онд үүссэн нийгмийн даатгалын сангаас олгосон хөнгөлөлт урамшууллын авлагыг тайлант хугацаанд бүрэн тооцоолон шилжүүлсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох” NO-201265511 төслөөс хандиваар 25,602.9 мянган төгрөгийн бусад хангамжийн материал авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох” NO-201265511 төслөөс хандиваар 215,745.8 мянган төгрөгийн барилга байгууламжийн хөрөнгө нэмэгдсэн байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 2.1 дэх заалтыг үндэслэн 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А-1/3285 тоот зөвшөөрлөөр, 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн №389 тоот тогтоолоор 23,847.3 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан.

Биет бус хөрөнгө өссөн нь 3,300.0 мянган төгрөгийн газар зүйн мэдээллийн системийн програм худалдаж авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,007,999.6 мянган төгрөг болж 126,573.1 мянган төгрөгөөр өсөхөд тайлант үеийн үр дүн 126,573.1 мянган төгрөг гарсан нь нөлөөлжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа тайлант онд 8,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 9,284.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 16.1 хувиар давж биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 1,284.5 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 624,158.7 мянган төгрөгийн урсгал зардлын төсөв батлагдсан байна.

Нийт зардалд улсын төсвөөс 616,158.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 8,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд урсгал зардлын батлагдсан төсөв 624,158.7 мянган төгрөг, гүйцэтгэл 624,096.4 мянган төгрөг болж 62.3 мянган төгрөгийн буюу 0.01 хувийн хэмнэлт 62.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсөв: Хандив тусламжаар 21,864.1 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 47,500.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 70,459.2 мянга, нийт 139,824.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт санхүүжилтийн 139,824.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл нэмж тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ. Үүнээс үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 9 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитаар нийт 1,480.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,480.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үйл ажиллагааны орлого болох нэвтрэх эрхийн тасалбарын орлогыг нарийвчлан шалгах. Эрхийн тасалбарын хяналтын талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 129 мэдээллийг хугацаанд нь, 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 20,026.3 мянган төгрөгийн зөрчилд 1,936.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг барагдуулж, 18,090.3 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийг 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлын төсвөөс 500.0 мянга, байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлын төсвөөс 980.0 мянга, нийт 1,480.0 мянган төгрөгийг ахмад настануудад хүндэтгэл үзүүлэх гарын бэлэг хүргүүлэхэд зарцуулсан байна.

Энэ нь “Үнэн ба зөв” батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Батлагдсан төсөв хэтрэх, төсвийг үр ашиггүй зарцуулах

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтыг мөрдөн ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг хөнгөлөлт олгох журмын дагуу байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмадуудад нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгосон. Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал батлагдаагүй учир өөр зардлаас зарцуулсан. Өгсөн зөвлөмжийг дагаж мөрдөж дээрх зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 135,189,642.62 | 173,893,629.76 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | - | - |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | - | - |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | - | - |
| 3121 | Төгрөг | - | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | - |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | - |
| 33 | АВЛАГА | 192,485.02 | - |
| 335 | Бусад авлага | 192,485.02 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 192,485.02 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 134,997,157.60 | 173,893,629.76 |
| 354 | Хангамжийн материал | 134,997,157.60 | 173,893,629.76 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,781,570.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 26,848,825.00 | 37,284,207.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 4,435,000.00 | 6,945,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,809,000.00 | 1,905,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 679,000.00 | 848,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 95,443,762.60 | 126,911,322.76 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 746,236,869.62 | 834,105,956.42 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 746,236,869.62 | 834,105,956.42 |
| 391 | Газар | 10,138,000.00 | 10,138,000.00 |
| 392 | Биет хөрөнгө | 735,805,536.34 | 820,894,623.18 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 94,418,320.00 | 297,505,017.63 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -385,965.90 | -34,724,948.08 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 600,369,447.20 | 585,219,020.20 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -213,025,613.36 | -256,080,332.70 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 139,351,589.52 | 147,372,737.04 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -29,477,818.94 | -51,646,612.08 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 158,215,683.09 | 163,456,832.09 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -31,929,222.67 | -55,753,267.35 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 24,304,705.00 | 34,304,705.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,035,587.60 | -8,758,528.57 |
| 393 | Биет бус хөрөнгө | 293,333.28 | 3,073,333.24 |
| 39301 | Програм хангамж | 700,000.00 | 4,000,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -406,666.72 | -926,666.76 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 881,426,512.24 | 1,007,999,586.18 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 881,426,512.24 | 1,007,999,586.18 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 881,426,512.24 | 1,007,999,586.18 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | 277,853,666.84 | 277,853,666.84 |
| 51101 | Өмч: - төрийн | 277,853,666.84 | 277,853,666.84 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 567,996,312.56 | 694,569,386.50 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 567,996,312.56 | 567,996,312.56 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 126,573,073.94 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 35,576,532.84 | 35,576,532.84 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 881,426,512.24 | 1,007,999,586.18 |

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 912,954,612.87 | 1,013,718,205.11 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 864,058,618.23 | 887,145,131.17 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 864,058,618.23 | 887,145,131.17 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 846,309,644.69 | 881,806,218.87 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 444,545,182.83 | 512,879,041.87 |
| 210101 | Үндсэн цалин | 374,684,415.63 | 284,069,448.47 |
| 210102 | Нэмэгдэл | 26,790,267.20 | 140,028,693.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,404,500.00 | 19,448,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 34,666,000.00 | 69,332,200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 56,428,304.92 | 64,060,614.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,661,867.98 | 44,076,914.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,452,732.58 | 4,996,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,573,628.08 | 3,996,699.99 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 885,462.84 | 999,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,854,613.44 | 9,991,800.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | - | - |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,211,954.00 | 10,020,445.72 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 128,052.00 | 208,445.72 |
| 210302 | Түлш, халаалт | 2,799,388.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | 53,500.00 | 32,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 13,231,014.00 | 9,780,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35,098,936.00 | 42,173,101.75 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,152,284.00 | 8,359,620.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,187,700.00 | 28,685,123.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,403,600.00 | 4,987,267.95 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 645,352.00 | 141,090.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,710,000.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 169,258.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 169,258.00 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,118,650.00 | 16,483,550.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 336,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,118,650.00 | 16,146,950.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 14,637,200.00 | 17,752,229.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | 7,828,829.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,637,200.00 | 9,923,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 54,604,926.43 | 61,481,897.86 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 51,001,900.43 | 58,043,519.86 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,488,000.00 | 1,485,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 812,000.00 | 812,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,092,200.00 | 977,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 210,826.00 | 163,678.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 215,495,232.51 | 156,955,338.35 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 433,000.00 | 4,689,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,734,000.00 | 1,788,880.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 211,328,232.51 | 150,476,758.35 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | - | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 17,748,973.54 | 5,338,912.30 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,249,051.00 | 3,990,671.00 |

| | | | |
|-------------|--|-----------------------------|------------------------------|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,249,051.00 | 3,990,671.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 499,922.54 | 1,348,241.30 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 499,922.54 | 1,348,241.30 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>48,895,994.64</u> | <u>126,573,073.94</u> |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | - |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>48,895,994.64</u> | <u>126,573,073.94</u> |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 698,320,792.72 | 765,269,499.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 8,341,100.00 | 9,284,488.28 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,341,100.00 | 9,284,488.28 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,341,100.00 | 9,284,488.28 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,341,100.00 | 9,284,488.28 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 689,979,692.72 | 755,985,011.52 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 568,863,800.00 | 616,158,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 568,863,800.00 | 616,158,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 121,115,892.72 | 139,826,311.52 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 21,867,115.52 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,543,270.00 | 47,500,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 113,572,622.72 | 70,459,196.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 698,320,792.72 | 765,269,499.80 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 698,320,792.72 | 765,269,499.80 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 680,571,819.18 | 759,930,587.50 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 446,162,800.00 | 512,483,579.85 |
| 210101 | Үндсэн цалин | 240,949,700.00 | 283,673,986.45 |
| 210102 | Нэмэгдэл | 119,072,200.00 | 140,028,693.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 16,808,700.00 | 19,448,700.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 69,332,200.00 | 69,332,200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 53,539,600.00 | 64,060,611.32 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,693,100.00 | 44,076,911.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,461,700.00 | 4,996,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,569,300.00 | 3,996,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 892,300.00 | 999,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,923,200.00 | 9,991,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,859,154.00 | 14,645,445.72 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 286,800.00 | 208,445.72 |
| 210302 | Түлш, халаалт | 2,250,140.00 | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | 91,200.00 | 32,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 13,231,014.00 | 14,405,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 29,945,170.00 | 31,762,561.75 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,197,970.00 | 830,630.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,711,000.00 | 25,274,473.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,403,600.00 | 5,387,267.95 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 632,600.00 | 270,190.00 |
| 2105 | Нормативт зардал | 313,260.00 | 336,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 313,260.00 | 336,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,805,045.00 | 15,636,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,533,000.00 | 369,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,272,045.00 | 15,267,100.00 |
| 2107 | Томилот, зочны зардал | 14,637,200.00 | 17,752,229.00 |

| | | | |
|-------------|--|----------------------|----------------------|
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 7,828,829.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,637,200.00 | 9,923,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 81,871,020.18 | 85,435,179.86 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 78,270,994.18 | 81,996,801.86 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,485,000.00 | 1,485,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 812,000.00 | 812,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,092,200.00 | 977,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 210,826.00 | 163,678.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,438,570.00 | 17,817,680.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,815,000.00 | 12,155,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,623,570.00 | 5,662,380.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 17,748,973.54 | 5,338,912.30 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 499,922.54 | 1,348,241.30 |
| 213101 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 499,922.54 | 1,348,241.30 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 17,249,051.00 | 3,990,671.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 17,249,051.00 | 3,990,671.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>00.00</u> | <u>00.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-----------------------|--|
| 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 267,715,666.84 | - | 444,607,778.47 | 712,323,445.31 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 267,715,666.84 | 00.00 | 444,607,778.47 | 712,323,445.31 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 48,895,994.64 | 48,895,994.64 |
| 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 277,853,666.84 | 35,576,532.84 | 567,996,312.56 | 881,426,512.24 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 277,853,666.84 | 35,576,532.84 | 567,996,312.56 | 881,426,512.24 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 126,573,073.94 | 126,573,073.94 |
| 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 277,853,666.84 | 35,576,532.84 | 694,569,386.50 | 1,007,999,586.18 |

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|----------------|----------------|-------------|---------|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 624,158,700.00 | 624,096,357.58 | 62,342.42 | 99.9 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 624,158,700.00 | 624,096,357.58 | 62,342.42 | 99.9 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 624,158,700.00 | 624,096,357.58 | 62,342.42 | 99.9 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 499,593,700.00 | 499,593,700.00 | - | 100.0 |
| Үндсэн цалин | 276,084,000.00 | 276,084,000.00 | - | 100.0 |
| Нэмэгдэл | 137,368,800.00 | 137,368,800.00 | - | 100.0 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 16,808,700.00 | 16,808,700.00 | - | 100.0 |
| Гэрээт ажлын хөлс | 69,332,200.00 | 69,332,200.00 | - | 100.0 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 62,449,200.00 | 62,449,200.00 | - | 100.0 |
| Тэтгэврийн даатгал | 42,465,500.00 | 42,465,500.00 | - | 100.0 |
| Тэтгэмжийн даатгал | 4,996,000.00 | 4,996,000.00 | - | 100.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 3,996,700.00 | 3,996,700.00 | - | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 999,200.00 | 999,200.00 | - | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 9,991,800.00 | 9,991,800.00 | - | 100.0 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 9,959,000.00 | 9,945,445.72 | 13,554.28 | 99.8 |
| Гэрэл, цахилгаан | 9,200.00 | 208,445.72 | -199,245.72 | 2,265.7 |
| Түлш, халаалт | 00.00 | 00.00 | - | - |
| Цэвэр, бохир ус | 20,000.00 | 32,000.00 | -12,000.00 | 160.0 |
| Байрны түрээс | 9,929,800.00 | 9,705,000.00 | 224,800.00 | 97.7 |
| Хангамж, бараа материалын зардал | 16,424,000.00 | 16,417,252.00 | 6,748.00 | 99.9 |
| Бичиг хэрэг | 831,400.00 | 830,630.00 | 770.00 | 99.9 |
| Тээвэр, шатахуун | 12,302,100.00 | 12,300,160.00 | 1,940.00 | 99.9 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,017,900.00 | 3,016,272.00 | 1,628.00 | 99.9 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 272,600.00 | 270,190.00 | 2,410.00 | 99.1 |
| Нормативт зардал | 336,600.00 | 336,600.00 | - | 100.0 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 336,600.00 | 336,600.00 | - | 100.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 1,972,500.00 | 1,959,600.00 | 12,900.00 | 99.3 |
| Багаж, техник, хэрэгсэл | 370,300.00 | 369,600.00 | 700.00 | 99.8 |
| Урсгал засвар | 1,602,200.00 | 1,590,000.00 | 12,200.00 | 99.2 |
| Томилолт, зочны зардал | 5,141,700.00 | 5,141,700.00 | - | 100.0 |
| Дотоод албан томилолт | 5,141,700.00 | 5,141,700.00 | - | 100.0 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22,941,700.00 | 22,935,179.86 | 6,520.14 | 99.9 |

| | | | | |
|--|----------------|----------------|---------------|-------|
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,500,000.00 | 19,496,801.86 | 3,198.14 | 99.9 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэлтогтоох | 1,485,000.00 | 1,485,000.00 | - | 100.0 |
| Даатгалын үйлчилгээ | 812,000.00 | 812,000.00 | - | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 977,700.00 | 977,700.00 | - | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 167,000.00 | 163,678.00 | 3,322.00 | 98.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 5340300.00 | 5317680.00 | 22,620.00 | |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 3,455,300.00 | 3,455,300.00 | - | |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,885,000.00 | 1,862,380.00 | 22,620.00 | 98.8 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 624,158,700.00 | 624,096,357.58 | 62,342.42 | 99.9 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 616,158,700.00 | 614,811,869.30 | 1,346,830.70 | 99.7 |
| Улсын төсвөөс санхүүжих | 616,158,700.00 | 614,811,869.30 | 1,346,830.70 | 99.7 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 8,000,000.00 | 9,284,488.28 | -1,284,488.28 | 116.1 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 8,000,000.00 | 9,284,488.28 | -1,284,488.28 | 116.1 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | 48 | 48 | - | 100.0 |
| Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 26 | 26 | - | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 8 | 8 | - | 100.0 |
| Гэрээт ажилтан | 13 | 13 | - | 100.0 |

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|--|----------------|----------------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 139,824,900.92 | 139,824,900.92 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 139,824,900.92 | 139,824,900.92 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 135,834,229.92 | 135,834,229.92 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 12,889,879.85 | 12,889,879.85 |
| Үндсэн цалин | 7,589,986.45 | 7,589,986.45 |
| Нэмэгдэл | 2,659,893.40 | 2,659,893.40 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 2,640,000.00 | 2,640,000.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,611,411.32 | 1,611,411.32 |
| Тэтгэврийн даатгал | 1,611,411.32 | 1,611,411.32 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 4,700,000.00 | 4,700,000.00 |
| Байрны түрээс | 4,700,000.00 | 4,700,000.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 15,345,309.75 | 15,345,309.75 |
| Тээвэр, шатахуун | 12,974,313.80 | 12,974,313.80 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,370,995.95 | 2,370,995.95 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 13,677,100.00 | 13,677,100.00 |
| Урсгал засвар | 13,677,100.00 | 13,677,100.00 |
| Томилолт, зочны зардал | 12,610,529.00 | 12,610,529.00 |
| Гадаад албан томилолт | 7,828,829.00 | 7,828,829.00 |
| Дотоод албан томилолт | 4,781,700.00 | 4,781,700.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 62,500,000.00 | 62,500,000.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 62,500,000.00 | 62,500,000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 12,500,000.00 | 12,500,000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 8,700,000.00 | 8,700,000.00 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,800,000.00 | 3,800,000.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,990,671.00 | 3,990,671.00 |
| Бусад урсгал шилжүүлэг | 3,990,671.00 | 3,990,671.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,990,671.00 | 3,990,671.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 139,824,900.92 | 139,824,900.92 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 139,824,900.92 | 139,824,900.92 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 21,864,115.52 | 21,864,115.52 |
| Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 47,500,000.00 | 47,500,000.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 70,457,785.40 | 70,457,785.40 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|------------------------------|--|--|-------------------------------------|
| Огноо: 2020.02.21 | Аудитын нэр: | Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: САГ-2020/72/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа | | Мянган төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|----------------|---------------------------------------|---|----------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 500.0 мянга, байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 980.0 мянга, нийт 1,480.0 мянган төгрөгийг ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх гарын бэлэг хүргүүлэхэд зарцуулсан байна. | 1,480.0 | Зөвлөмж өгөх | Нягтлан бодогч | П.Оюунтунгалаг |
| | Дүн | 1,480.0 | | | |

